



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

ШҮҮХИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС

ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ

САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



АГУУЛГА

УДИРТГАЛ	2
(1) Судалгааны зорилго, хамрах хүрээ.....	2
(2) Судалгааны мэдээлэл цуглуулсан арга.....	2
(3) Судалгааны түүвэр, байршил.....	2
(4) Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах ажиллагаа.....	3
1. ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ.....	4
2. ШҮҮХ ӨӨРЧЛӨГДСӨН ЭСЭХ, ШҮҮХИЙН ӨӨРЧЛӨЛТ	9
3. ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ, ТЭГШ БАЙДАЛ.....	11
4. ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ШҮҮГЧИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ТӨСӨӨЛӨЛ	14
5. ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛД ЦААШИД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ	16
ДҮГНЭЛТ.....	19
ХАВСРАЛТ.....	21



УДИРТГАЛ

2013 онд шинэчлэн байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн үйлчилгээг ил тод нээлттэй, хүртээмжтэй болгох, олон нийтийн хяналтыг тогтоох нөхцөлийг бүрдүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх байдалд онцгой анхаарч ирсэн. Энэ хүрээнд 2014 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүх ба олон нийт” хөтөлбөрийг баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн 2017 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” сэдэвт олон нийтийн санал асуулга явуулах тухай тушаал баталсан бөгөөд уг судалгааг жилд 2-оос доошгүй удаа авах, ингэхдээ нөхцөл байдлыг бодитой үнэлэх үүднээс шүүхээр үйлчлүүлсэн иргэд болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн хүрээнд явуулж байх юм.

(1) Судалгааны зорилго, хамрах хүрээ

Шүүх ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх, эргэх холбоо тогтоох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгоход энэ судалгааны зорилго оршино.

Дээрх зорилгод үндэслэн олон нийтийн санаа бодлыг дараах байдлаар томьёолж, мэдээлэл цуглуулав. Үүнд:

- Шүүхийн үйлчилгээ, хүндрэл, бэрхшээл;
- Шүүх өөрчлөгдсөн эсэх, шүүхийн өөрчлөлт;
- Шүүхэд итгэх иргэдийн итгэл, шударга байдал;
- Шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн талаарх иргэдийн төсөөлөл;
- Шүүхийн шинэтгэлд цаашид тулгарч буй сорилт;

(2) Судалгааны мэдээлэл цуглуулсан арга

Судалгааны мэдээллийг Монгол Улсын нийт шүүхийн хэмжээнд социологийн судалгааны санал асуулгын аргыг ашиглан гүйцэтгэв.


Анкетын судалгаа: Олон нийтийн үнэлэмжийг бодитой тогтоож, цаашид үйл ажиллагааны чиглэлийг тогтоож, шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх арга замыг тодорхойлоход асуулгын судалгааны аргыг ашигласан бөгөөд нийгмийн судалгааны бусад аргуудыг хавсарсан байдлаар ашиглаагүй болно.

Жич: Анкет 2 төрөл байх бөгөөд шүүхээр үйлчлүүлж байсан болон байгаагүй иргэд гэсэн хоёр агуулгатай болно.

(3) Судалгааны түүвэр, байршил

Судалгаанд шүүхээр үйлчлүүлсэн 1520, шүүхээр үйлчлүүлээгүй 1544 нийт 3064 иргэн оролцсон байна. /Дэлгэрэнгүй задаргааг хавсралтаас үзнэ үү/.

Судалгаанд оролцогчдын насны бүлэг (Шүүхээр үйлчлүүлээгүй иргэд n=1570)



“Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын судалгааг шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлээгүй нийт 3064 иргэнээс авсан. Шүүхээр үйлчлүүлээгүй 1544 иргэн хамрагдсанаас 33.2 хувь нь 18-30 настай, 26.3 хувь нь 31-40 настай, 24.2 хувь нь 41-50 настай, 11.1 хувь нь 51-60 настай, 5.3 хувь нь 61 ба түүнээс дээш настай хүмүүс хамрагдсан байна.

Мэдээллийн нууцлалыг хангах: Санал асуулгыг авахдаа иргэд олон нийтээс бусдын нөлөөлөлд автахгүй байх, өөрийн үзэл бодлоо нээлттэй, шударгаар илэрхийлэх боломжоор хангаж ажилласан /Дэлгэрэнгүй задаргааг хавсралтаас үзнэ үү/.


(4) Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах ажиллагаа

Судалгааны мэдээллийг шүүхийн тамгын газруудаас Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс хүлээн авч, битүүмжлэлийг задалж, санал асуулгын анкетыг тоолж, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн мэдээллийн санд шивж оруулан, үр дүнг нийгмийн судалгааны SPSS 20.0 программыг ашиглан бодож гаргав.

1. ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ


Шүүхээр үйлчлүүлээгүй иргэд

График 1.1. Таны танил шүүхээр үйлчлүүлсэн эсэх



Судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлээгүй иргэдийн 45 хувьд тэдний хэн нэгэн танил болон ойр тойрны хүмүүс шүүхээр үйлчлүүлсэн байна. Өмнөх 2018 оны 2 сард хийгдсэн судалгаагаар 50.3 хувь байсан. Энэ нь ард иргэдийн ½ нь ямар нэгэн тохиолдлоор тогтмол шүүхтэй холбоотой (дам үйлчлүүлсэн) байна.

График 1.2. Хэрэв иргэд шүүхэд ямар нэг асуудлаар хандвал (харьцуулалт)



Хэрэв шүүхэд ямар нэг асуудлаар хандвал иргэдийн 55 хувь (37+18) буюу талаас илүү хувь нь шүүх өөрчлөгдсөн гэж сонссон тул санаа нэг их зовохгүй бөгөөд шүүх, шүүгчид асуудлаа хуулийн дагуу зөв ойлгуулахыг хичээнэ гэж хариулснаас үзвэл шүүхээр огт үйлчлүүлээгүй иргэдийн хувьд шүүх асуудлыг нь шударга, тал харалгүй, хуулийн дагуу шийднэ гэдэгт итгэх хувь өндөр байгааг харуулж байна. Мөн шүүхийн өөрчлөлтийг мэдсэн, сонссон байдал нь 1.5 жилийн өмнөх судалгааны дүнгээс сүүлийн жилүүдэд 3 хувиар өсөж 18 хувийн үзүүлэлттэйгээр тогтмол байна. Энэ нь 2013 оноос эрчимтэй хэрэгжиж буй шүүхийн шинэтгэл, түүний үр дүнг нийгэм улам гүнзгийрүүлэн хүлээж авч буйн илрэл гэж болохоор байна.

Харин иргэдийн 17 хувь (12+5) нь шүүхэд ямар нэг асуудлаар хандвал санаа зовно, танил талаараа дамжуулж яриа, хөөрөө хийлгэнэ гэж хариулснаас харахад иргэдийн бага хэсэг нь шүүхийн бие даасан байдлын талаарх ойлголт дутмаг бөгөөд шүүх тал хардаг төрийн захиргааны байгууллага гэсэн хуучинсаг хэвшмэл ойлголт байсаар байна. Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан байдал, шүүхийн шинэтгэлийн талаар олон нийтийг мэдээллээр хангах ажлаа эрчимтэй хэвээр үргэлжлүүлэх, үр дүнг тооцож ажиллах шаардлага байсаар байгааг харуулж байна.

Үлдсэн 28 хувь буюу 1/3 нь яах талаар хэлж мэдэхгүй байна гэжээ. Энэ нь иргэд эрхээ хамгаалуулах тал дээр тодорхой ухамсартай бодолгүй, идэвхгүй байдалтай байгааг нөгөө талаас иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг байгааг харуулж байна. Иймд Засгийн газрын зүгээс хууль сурталчлах үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна.


Шүүхээр үйлчлүүлсэн иргэд

График 1.3. Хэдэн удаа шүүхээр үйлчлүүлж байна вэ?




“Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын судалгааг шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлээгүй нийт 3064 иргэнээс санал авсан. Шүүхээр үйлчлүүлсэн 1520 иргэн хамрагдсанаас 35.8 хувь нь өмнө нь 1 удаа үйлчлүүлж байсан, 32.3 хувь нь өмнө нь олон удаа үйлчлүүлж байсан, 31.9 хувь нь анх удаагаа шүүхэд хандсан иргэд байна. Үүнээс харахад дийлэнх нь буюу 69.1 хувь нь шүүхийн үйлчилгээг 2 ба түүнээс дээш удаа авсан иргэд байна.

График 1.4. Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд ямар нэг хүндрэл гарсан уу?



Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж, үйлчилгээ авахад иргэдийн 4/5 нь ямар нэг хүндрэл, бэрхшээл гараагүй гэснээс харахад шүүхийн үйлчилгээ ноцтой дутагдалгүй, ерөнхийдөө хэвийн түвшинд явагдаж байна гэж үзэхээр байна. Мөн өмнө хийгдсэн судалгаануудын үр дүнгээс бэрхшээл тулгарсан байдал тогтмол буурсан, эерэг үзүүлэлттэй байна. Үүнийг 2013 оноос эхлэн хэрэгжиж байгаа Шүүхийн тухай багц хуулиудын хүрээнд шүүхийн эрх зүйн орчин сайжирч, шинэтгэл амжилттай хэрэгжиж байгаа, хэрэг маргааны төрлөөр шүүхийг дагнуулан байгуулж, шүүгч мэргэшин ажиллаж байгаа, хэргийн ачаалалтай уялдуулан шүүгчдийн орон тоог нэмэгдүүлсэн, шүүгчдийн бүрэлдэхүүнийг шинэ шүүгчдээр сэлбэсэн, шүүхийг үйлчилгээний байгууллага болгох талаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн гэж үзэж болно. Үүнийг орон нутаг болон нийслэлийн шүүхээр харьцуулж харвал дараах байдалтай байна.

График 1.5. Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд хүндрэл гарсан эсэх



Нийслэл дэх шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн 28.5 хувь, орон нутагт байрлах шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн 16.5 хувь нь “шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарсан” гэж хариулжээ. Нийслэл, орон нутгийн судалгааны үр дүн ялгаатай байгаа бөгөөд “хүндрэл тулгарсан” гэж хариулсан хүний тоо нийслэлд 12 хувиар зөрүүтэй байна. Харин 2017 оны 6 сарын судалгаагаар нийслэл дэх шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн 36.5 хувь нь “шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарсан” гэж хариулж байсан нь 28.5 хувь болж 8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


2013 оноос эхлэн хэрэгжүүлсэн шүүхийн шинэчлэлийн хүрээнд нийслэл, орон нутаг дахь шүүхийн хэргийн ачааллыг тэнцвэржүүлэх үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2018 оны хагас жилийн байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хувьд хэргийн ачаалал дүүргийн шүүхийн нэг шүүгчид 63.1 хэрэг, орон нутгийн шүүхийн нэг шүүгчид 37.7 хэрэг, иргэний хэргийн шүүхийн хувьд дүүргийн шүүхийн нэг шүүгчид 162.2 хэрэг, орон нутгийн шүүхийн нэг шүүгчид 143.1 хэрэг, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэргийн ачаалал улсын дундаж 11.7 хэрэг бөгөөд нийслэл дэх захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгчид 20.5 хэрэг, орон нутагт байрлах дийлэнх шүүхийн хувьд 1 шүүгчид 3 хүрэхгүй хэрэг тус тус ногдож байгаа юм¹. Захиргааны хэргийн шүүхийн хувьд нийслэлд 7 дахин, эрүү болон иргэний хэргийн шүүхийн хувьд нийслэлд тус бүр 20-30 орчим хувиар өндөр ачаалалтай байгаа нь судалгааны үр дүнд нөлөөлсөн гол хүчин зүйл байж болох талтай. Түүнчлэн төвлөрсөн хот, суурин газар болохын хувьд нийслэл дэх шүүхүүдийн шийдвэрлэж буй хэргүүд илүү ээдрээ, төвөгтэй байхыг үгүйсгэхгүй. Цаашид нийслэл дэх

¹ Монгол Улсын шүүхийн 2018 оны хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ

шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд тулгарсан нийтлэг бэрхшээлийг нарийвчлан судалж, илрүүлэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Судалгаанд оролцогчдын 1/5 буюу 19.9 хувь нь шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарсан гэж хариулсан нь нийт шүүхүүдийн үйлчилгээнд дутагдалтай тал, сайжруулах зүйлүүд байгааг харуулж байна. Тулгарсан хүндрэл, бэрхшээлийг дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

График 1.6. Ямар бэрхшээл тулгарсан эсэх




Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд гарч буй нийтлэг хүндрэлүүдийг авч үзвэл тэдгээр нь шүүхийн дэд бүтэц, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа болон шүүгч шударга, тэгш хандаагүй гэсэн байдалтай аль алинтай нь холбогдож байна.

Шүүгчдийн тухайд судалгаанд оролцогчдын 19.1 хувь нь хэргийн оролцогчдод шударга, тэгш хандаагүй, 12.2 хувь нь харилцаа хандлага таалагдаагүй зэрэг нь хүндрэлтэй байсан гэж хариулжээ. Энэ нь хэдийгээр шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн субъектив үнэлэлтээс хамаарсан дүн боловч шүүгч нь Монгол Улсын хууль тогтоомж, Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасны дагуу ёс зүйн өндөр хэм хэмжээг сахиж, шударга ажиллахаас гадна тийнхүү харагдахуйцаар үйлдэл, харилцаагаа авч явах үүргээ хэрэгжүүлэхэд цаашид тодорхой хэмжээнд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны тухайд судалгаанд оролцогчдын 16.9 хувь нь үйлчилгээ муу, хүнд сурталтай, 8.4 хувь нь ажилтнуудын захиргааны ажилтны харьцаа хандлага тааруу гэжээ. Иймээс шүүхийн тамгын газрууд дээр байдлыг сайжруулах, ажилтнуудын харилцаа хандлагын тал дээр анхаарч сургалт, сурталчилгаа явуулах шаардлага бий.

График 1.7. Ямар бэрхшээл тулгарсан эсэх /Нийслэл, орон нутаг/




Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд гарч буй нийтлэг хүндрэлүүдийг орон нутаг болон нийслэлд байрлах шүүхүүдээр харьцуулж үзвэл өндөр үзүүлэлттэй байгаа гурван асуудлын нэг нь төдийлөн ялгаагүй, хоёр асуудал бага зэрэг ялгаатай байгааг харж болно. “Шүүхийн байр, дэд бүтэц муу” гэсэн байдал нийслэлд байрлах шүүхүүдийн хувьд орон нутгийн шүүхээс 6 хувиар илүү байна. Мөн нөгөө талдаа орон нутагт байрлах шүүхийн “Шүүгч шударга, тэгш хандаагүй” гэж шүүмжлэх үнэлгээ нийслэлийнхээс өндөр байна.

Дээрх байдал нь нийслэлд байрлах шүүхүүдийн ажлын ачаалал өндөр, шүүхээр үйлчлүүлэгсдийн тоо их байгаатай холбоотой бөгөөд ажлын ачаалал, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, нийслэл дэх шүүхийн дэд бүтцийг сайжруулах зайлшгүй шаардлага, хэрэгцээ байгааг иргэдээс авсан судалгааны үр дүн илтгэж байна. Харин орон нутагт байрлах шүүхийн шүүгчид харилцан ашиг сонирхлын зөрчилтэй талуудын маргаан, гомдлыг эцэслэн шийдвэрлэж байдаг тул шүүгчийн шийдвэр туйлын утгаараа талуудад таалагдах, эс таалагдах харьцаа 50:50 хувьтай байх хэдий ч хэргийн оролцогч талууд тэдгээрийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч нартай зүй зохистой харьцах, харьцаандаа цаашид анхаарах шаардлагатайг харуулж байна.

2. ШҮҮХ ӨӨРЧЛӨГДСӨН ЭСЭХ, ШҮҮХИЙН ӨӨРЧЛӨЛТ

График 2.1. Шүүхээр үйлчлүүлэхэд ямар сэтгэгдэл төрсөн бэ?




Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхэлснээс хойших шүүхийг өмнөх байдалтай нь харьцуулж шүүхээр үйлчлүүлж байсан иргэдээс шүүх өөрчлөгдсөн буюу шүүхийн шударга байдал, үйлчилгээ сайжирсан эсэхийг асуухад иргэдийн тал хувь нь буюу 43 хувьд шүүх шинэчлэгдэн сайжирч байгааг мэдэрсэн гэсэн хариулт өгснөөс үзвэл шүүхийн шинэтгэл бодитой үр дүнд хүрснийг иргэдийн тал орчим хувь нь шууд хүлээн зөвшөөрч байна гэж үзэж болохоор байна.

Харин үлдсэн 57 хувь нь шүүх өөрчлөгдсөн гэдгийг хэлж мэдэхгүй байна, өөрчлөлт мэдрээгүй гэж хариулснаас харахад иргэдийн зарим хэсэгт шүүхийн шинэтгэлийн хэрэгцээ шаардлага, үйл явц, үр дүн, шударга шүүхийн зүгээс иргэдийн амьдрал үзүүлэх ач холбогдлын талаар бодит мэдээлэл, сурталчилгааг хангалттай хүргээгүй байна гэж үзэхээр байна. Иймд олон нийтийг шүүхийн мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Шүүхийн өөрчлөлтийн талаар орон нутаг болон нийслэлээр харьцуулж үзвэл төдийлөн ялгаатай өөрчлөлт харагдахгүй байгаа нь шүүхийн шинэтгэлийн бодлого нийслэл орон нутагт ялгамжгүй, тэгш явагдаж байгааг харуулж байна.

График 2.2. Шүүх яаж өөрчлөгдсөн бэ?




Шүүхийн шинэтгэлийн 11 гол үр дүнгээс иргэд алийг нь илүү их мэдэрсэн, тэдний амьдралд ач холбогдолтой гэж үзэж байгааг асуухад шүүхийн үйлчилгээ өмнөхөөсөө мэдэгдэхгүйц сайжирсан, шинэтгэл ерөнхийдөө мэдрэгдэж байна, эвлэрүүлэн зуучлал үр дүнтэй хэрэгжиж байгаа гэдэгтэй иргэд хамгийн их санал нийлжээ. Тухайлбал, шүүхээр үйлчлүүлсэн иргэд үйлчлүүлээгүй иргэдээсээ хол зөрүүтэйгээр шүүхийн үйлчилгээ сайжирсан байгааг илүү мэдэрчээ. Мөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлал 2014 оноос манай улсад хэрэгжиж шүүхэд ирж буй иргэдийн нэхэмжлэл өргөдөл тутмын 1/5 -ийг эвлэрлийн журмаар шийдвэрлэж байгаа нь шүүхийн ачааллыг 20 хувиар бууруулж байгаа эерэг үзүүлэлт юм. Ингэснээр эвлэрүүлэн зуучлал нь шуурхай явагдаж, цаг хугацаа, мөнгийг хэмнэж, нийгэмд энх тайванч уур амьсгалыг авчирснаар иргэдийн амьдрал, аж ахуйн үйл ажиллагаанд хамгийн түрүүнд бодитоор тусч буй шүүхийн шинэтгэлийн үр дүн болсныг энэ судалгааны үр дүн дахин дахин харуулж байна.

Түүнчлэн шүүхийн үйлчилгээнд цахим инновац нэвтэрсэн, шүүхийн шийдвэр нээлттэй, үйл ажиллагаа нь ил тод болсон гэдэгтэй иргэдийн олонх санал нийлжээ. Энэ нь шинэтгэлийн хүрээнд www.shuukh.mn сайтад шүүхийн шийдвэрийг нээлттэй тавьдаг болсон, шүүх хуралдааны бичлэгийг нөхөж үзэх, иргэдийн шүүхийн байранд очиж үйлчлүүлэх орчин нөхцөлийг нээлттэй болгосон зэрэг нь иргэдийн шүүхэд итгэл итгэл нэмэгдэхэд нөлөөлжээ.

Харин шүүх бие даасан захиргаатай болсон, шүүхийн хараат бус байдал дээшилсэн, хүний нөөц шинэчлэгдэж байгаа, шүүх дагнаж, шүүгч мэргэшсэн зэрэг шинэтгэлийн өөрчлөлтүүд иргэдэд туссан түвшин доогуур байна. Энэ нь шүүхийн шинэтгэлийн дээрх чиглэлүүд нь шүүхийн өөрийн тогтолцоо, байгууллагын дотоод ажил, хүчин зүйлтэй холбоотой буюу иргэдийн амьдралд шууд хамааралгүй чиглэлүүд тул иргэд тухайлан ач холбогдол өгөхгүй байгаатай холбоотой байж болох юм. Гэвч эдгээр чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг илтгэнэ.


3. ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ, ТЭГШ БАЙДАЛ

График 3.1. Шүүх хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэнэ гэдэгт хэр итгэж байна вэ?



Шүүхээр үйлчлүүлсэн иргэдээс **шүүх хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэнэ гэдэгт хэр итгэж байна вэ?** гэж асуухад **10 сарын өмнөх энэ судалгааны дүнгээс 1.4 хувиар өсөж 67.2 хувь нь шүүхдээ итгэнэ** гэж шууд хариулжээ. Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2007 оны судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 30 хувиас бага байдаг байсан бол энэ удаагийн судалгаагаар 67.2 хувь нь шүүхэд итгэдэг гэж үзсэн нь шүүхийн шинэтгэлийн үр дүнд шүүхэд итгэх иргэдийн итгэл дээшилснийг харуулж байна. Энэ нь шүүхийн шинэтгэлийн үр дүнг хэмжих хамгийн гол үзүүлэлт мөн. Шүүхэд итгэх иргэдийн итгэл нь тогтмол хөдөлгөөнгүй үзүүлэлт биш тул цаашид иргэдийн итгэлийг тасралтгүй нэмэгдүүлэх, үзүүлэлтийг бууруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй юм. Шүүхэд итгэдэггүй гэж хариулсан иргэдийн хувь бага буюу 6.3 хувь боловч өмнөх судалгааны дүнгээс 2 дахин орчим өссөн байгаагаас харвал шүүхэд итгэх иргэдийн байдал тун эмзэг байгааг харуулж байна.


График 3.2. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл /Нийслэл, орон нутаг/



Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийн байдлыг орон нутаг болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж харвал нийслэлд 60 орчим хувь, орон нутагт 70 гаруй хувь нь шүүхэд итгэдэг гэж хариулсан нь 2000-аад оны эхэн үеийн судалгааны дүнтэй харьцуулахад харьцангуй өндөр өсөлттэй үзүүлэлт юм. Үүнийг 2013 оноос хэрэгжүүлж буй шүүхийн шинэчлэлийн эерэг үр дүнд гэж харж байна. Гэсэн хэдий ч шүүхэд итгэх итгэл өөрөө маш эмзэг бөгөөд иргэдийн итгэлийг бууруулахгүй байх, тогтмол өсгөхөд байнга анхаарч ажиллах шаардлагатай. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 17-30 орчим хувь нь шүүхэд итгэдэггүй, эсхүл эргэлзэж байгаа гэж хариулсанд


анхаарал хандуулж, судлан тодруулж, эергээр өөрчлөх чиглэлд шаардлагатай арга хэмжээ авах хэрэгтэй. Энэ байдал нийслэлд байрлах шүүхүүдэд түлхүү ажиглагдаж байна.

График 3.3. Шүүхийн шийдвэр Таны эсрэг гарвал Та ямар алхам хийх вэ?




Шүүхийн шийдвэр өөрийнх нь эсрэг гарсан тохиолдолд шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 49 хувь нь яагаад тийм шийдвэр гарсныг судална, 41 хувь нь шууд давж заалдана гэж хариулжээ. Шүүхийн шийдвэрийг давж заалдах Үндсэн хуульд заасан эрхээ эдлэх нь иргэдийн эрхийн асуудал тул зүй ёсны хэрэг юм. Шүүгчийг хардана гэсэн хариулт харьцангуй бага 3 хувь байгаа нь иргэд шүүгчийн хараат бус байдалд итгэж байгааг илтгэх үзүүлэлт гэж үзэхээр байна.

График 3.4. Шүүхийн шийдвэр Таны эсрэг гарвал Та яах вэ? /Нийслэл, орон нутаг/



Орон нутаг болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж үзвэл хоорондоо хол зөрүүгүй, харилцан тэнцвэртэй байна.


График 3.5. Шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр ялгаварладаггүй



Шүүх хэргийн оролцогчдыг ялгаварладаг эсэх талаар иргэдээс асуухад шүүхээр үйлчлүүлж байсан болон үйлчлүүлж байгаагүй иргэдийн төсөөлөл хоорондоо эрс ялгаатай байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн 50.6 (20.3+30.3) хувь нь шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр хэргийн оролцогчдыг ялгаварладаггүй гэж, 20 (14.1+5.9) хувь нь ялгаварладаг гэж үзсэн бол шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн 67.9 (31+36.9) хувь нь шүүх ялгаварладаггүй гэж үзжээ. Шүүхээр үйлчлүүлж байсан иргэд үйлчлүүлж байгаагүй иргэдтэй харьцуулахад шүүх иргэдийг ялгаварладаггүй гэсэн хариулт 17.9 хувиар илүү байна. Энэ нь шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэд шүүхийн талаарх бодит мэдээллээс хол байгааг харуулж байгаа бөгөөд төсөөлөл, таамаглалд тулгуурлан асуултад хариулсан байж болох талтай. Харин шүүхээр үйлчлүүлсэн иргэд шүүх шударга, тал татдаггүй гэдгийг илүү мэдэрдэг нь судалгааны дүнгээс харагдаж байна.

4. ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ШҮҮГЧИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ТӨСӨӨЛӨЛ

График 4.1. Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар




Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүгчид тавигдах болзол шаардлага, тэдгээрийг үнэлэх арга ажиллагааг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар шинэчлэн баталсан билээ. Шинэ сонгон шалгаруулалтын талаар иргэдийн 50 гаруй хувь нь буюу олонх нь эерэг бодолтой байгаа нь тэдний зөв хүнийг олж байна, гайгүй байх гэж итгэж байна гэсэн хариултыг түлхүү сонгосноос харагдаж байна.

Харин иргэдийн 20 орчим хувь нь шүүгчийн сонгон шалгаруулалтыг хүмүүс шүүмжилж байсныг сонссон, нэг л биш байна гэж хариулжээ. Үлдсэн 20 гаруй хувь нь энэ асуудлыг дүгнэж хэлж мэдэхгүй, мэдээлэлгүй байна.


Шүүхийн шинэтгэлээс өмнө шүүгчийн сонгон шалгаруулалт салбарын болон иргэдийн дунд хамгийн их шүүмжлүүлдэг сэдэв байсан. Шүүхэд цус ойртлоо, шүүх дотроосоо буюу явцуу хүрээнээс шүүгчид сонгогдож байна, сонгон шалгаруулалтад хүний нөлөө их, танил талтай нь шалгардаг гэсэн шүүмжлэлүүд байв. Харин шинэтгэлийн хүрээнд сонгон шалгаруулалтыг хүнээс хамгийн бага хамааралтай байхаар, технологийн дэвшил ашиглан хийж, бүх хуульчдыг тэгш өрсөлдөх бололцоог олгосны үр дүнд хамгийн их шүүмжлүүлж байсан энэ сэдвээр иргэдийн олонх нь эерэг бодолтой болсон нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын үр дүн юм.

График 4.2. Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар /Нийслэл, орон нутаг/



Орон нутагт байрлах шүүх болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж үзвэл нийслэлд байрлах шүүхүүдэд үйлчлүүлсэн иргэд шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар илүү шүүмжлэлтэй хандаж байгаа нь харагдаж байна.


График 4.3. Өөрийн нутаг дэвсгэрийн шүүгчийн талаарх Таны бодол



Шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн 42.6 хувь нь өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийн шүүхийн шүүгчийн талаарх эерэг бодолтой байдаг байна. Тухайлбал, тэдний 31.6 хувь нь шүүгчдээ хүндэтгэх сэтгэл төрдөг гэсэн бол 11.1 хувь нь шүүгчдээ аргагүй л шүүгч хүн гэж боддог гэж үзжээ. Харин 28.8 хувь нь боломжийн, 8.8 хувь шүүгчид сэтгэл дундуур байдаг нь их жин эзлэхгүй байгаа нь шүүгчид итгэх итгэлийн үр дүн гэж харж болно.

Шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн хувьд мөн ихэнх нь шүүгчдийн талаар эерэг бодолтой байдаг бөгөөд тэдний 1/3 нь шүүгчдийн талаар тухайлан үнэлэлт дүгнэлт өгч байгаагүй гэж хариулжээ.

График 4.4. Өөрийн нутаг дэвсгэрийн шүүгчийн талаарх Таны бодол /Нийслэл, орон нутаг/




Өөрийн нутаг дэвсгэрийн шүүгчийн талаар иргэд, олон нийт юу гэж боддог талаар орон нутаг болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж харвал ерөнхий дүнгээс хол зөрөөгүй байна.

5. ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛД ЦААШИД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ


Санал асуулгын энэ хэсэгт шүүхийн шинэтгэлийн хүрээнд ямар ололтууд иргэдэд илүү хүрсэн бэ?, цаашид бид юун дээр анхаарах шаардлагатай вэ? гэсэн 2 багц асуултыг иргэдээс асуусан. Тус бүр 10 гаруй бодомж сонголттой багц асуултаас шүүхийн шинэтгэлийн хүрээнд иргэдэд харьцангуй бага мэдрэгдсэн гэж үзсэн чиглэлүүд нь цаашид анхаарах шаардлагатай гэж үзсэн шинэтгэлийн чиглэлүүдтэй давхцаж байна. /График 5.1. болон график 5.2./

График 5.1. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд



Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүгч шударгаар хэрэг маргааныг шийдвэрлэдэг, шүүгч ёс зүйгээ сахидаг, шүүхээр үйлчлүүлэхэд түргэн шуурхай болсон гэдэгтэй иргэд хамгийн ихээр санал нийлж байгаа нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийн үр дүн болж байна.

График 5.2. Цаашид юунд анхаарах шаардлагатай вэ?



Шүүхийн шинэтгэлийн хүрээнд цаашид анхаарах шаардлагатай чиглэлүүдийн хувьд иргэдийн 40.6 хувь нь шүүгчид сайн хүнийг томилох нь хамгийн чухал гэж үзжээ. Энэ нь шүүгч хариуцлагатай байдаг, шүүгчийн зан харьцаа, эелдэг, зөөлөн байдаг (График 5.1) зэрэг үзүүлэлтүүд шинэтгэлийн хүрээнд өссөн гэж үзсэн иргэдийн хувь доогуур байгаатай уялдаж байна.

Иргэдийн 40 орчим хувь нь шүүгч хараат бус ажиллах баталгааг бүрдүүлэхэд цаашид онцгой анхаарах шаардлагатай гэж үзжээ. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг болсноор шүүгчид эрх мэдэл, хөрөнгө чинээтэй хүн дарамтлах маягаар шууд нөлөөлөх явдал эрс буурсан шинэтгэлийн нэг ололт юм. Гэвч энэ судалгааны үр дүнгээс харахад шүүгчид хувийн танил нь буюу дээд шатны албан тушаалтан гуйх буюу хариу нэхэх хэлбэрээр нөлөөлөх байдал байсаар байна гэж иргэд үзжээ. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөл цаашид шүүгчид нөлөөлдөг танил талын нөлөөг хаах чиглэлээр ажиллах шаардлагатайг судалгааны дүн харуулж байна.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд 2014 оноос хойш шүүгчдийн бүрэлдэхүүнийг олон шинэ шүүгчээр нэмэгдүүлсэн ч иргэд шүүгчдийн мэдлэг, ур чадвар хангалтгүй гэж үзэж байгаа хувь өндөр хэвээр байна. Эдгээр нь цаашид шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

Цаашид шүүхийн мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг сайжруулах шаардлагатай гэж иргэдийн 36.3 хувь нь үзжээ. Шүүхийг нээлттэй болгох чиглэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн хийсэн ажлын үр дүнд сүүлийн 4 жилд эрс дэвшил гарсан. Энэ үйл явцыг улам гүнзгийрүүлж шүүх ба олон нийтийн харилцаа, хэвлэл мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх шаардлага байгааг тус судалгаа илтгэж байна. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийг цахимжуулах, шүүхийг үйлчилгээний байгууллага болгох ажлыг эрчимжүүлэх, хүнд суртлыг арилгах, үйл ажиллагааг хялбар, дөт, иргэдэд ойлгомжтой болгох чиглэлээр урт хугацааны шат дараалсан бодлого, арга хэмжээ авах шаардлагатай юм. Улсын Их Хурал, Засгийн газар ч шүүхийн үйлчилгээг орчин үежүүлэх чиглэлээр төсөв хөрөнгийг шийдвэрлэх, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажилд анхаарах шаардлагатайг энэ судалгаанаас харж болно.



ДҮГНЭЛТ

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх, эргэх холбоо тогтоох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх, шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор явуулсан анхан болон давж заалдах шатны шүүхийн 39 тамгын газраар үйлчлүүлсэн 1520, мөн тухайн тамгын газарт харьяалах орон нутгийн 1544, нийт 3064 иргэд, олон нийт хамрагдсан санал асуулгын үр дүнг боловсруулж дараах дүгнэлтийг танилцуулж байна. Судалгааг өмнө нь 2017 он, 2018 оны 1 дүгээр сар хийсэн. Энэ судалгаа нь 3 дахь удаагийнх нь юм. Зарим голлох үзүүлэлтүүдийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж тооцсон.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байна

Энэ санал асуулгын судалгаагаар иргэдийн **67.2 хувь шүүхэд итгэдэг** гэсэн үзүүлэлт гарсан нь шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байгааг харуулж байна. Энэ нь оны эхэнд хийгдсэн судалгааны дүн (65.8%)-ээс 1.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин шүүхийн шинэтгэл эхлэхээс өмнөх 2007 оны судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 30 орчим хувьтай байсан бол 2015 оны байдлаар иргэдийн итгэл 60-80 хувь болж өссөн гэсэн хөндлөнгийн байгууллагын судалгааны үр дүнг энэ удаагийн судалгаа нотолж байна.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байгаа нь энэ санал асуулгын бусад хэсгээр давхар нотлогдож байна. Тухайлбал, шүүхийн шийдвэр тухайн иргэний эсрэг гарвал иргэд шүүхийг шууд хардахгүй 90 хувь нь яагаад ийм шийдвэр гарсныг судлах буюу давж заалдана гэжээ.

Судалгаагаар шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр хүнийг ялгаварладаггүй гэж иргэдийн 50.6 хувь нь үзжээ. Шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн олонх нь буюу 67.9 хувь нь өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийн шүүхийн шүүгчийн талаар эерэг бодолтой байна. Мөн иргэдийн 50 гаруй хувь нь шүүгчийн сонгон шалгаруулалтаар зөв хүнийг олж байна, итгэж байна гэж хариулсан зэргээс үзэхэд шүүхэд итгэх иргэдийн итгэл энэ судалгаагаар бодитой тодорхойлогджээ гэж үзэхээр байна.

Шүүхийн шинэтгэл иргэдэд хүрч байна

Иргэдийн 43 хувьд шүүх шинэчлэгдэн сайжирч байгааг мэдэрсэн гэсэн хариулт өгснөөс үзвэл шүүхийн шинэтгэл бодитой үр дүнд хүрснийг иргэдийн тал орчим хувь нь шууд хүлээн зөвшөөрч байна гэж үзэж болохоор байна.

Иргэд шинэтгэл ерөнхийдөө мэдрэгдэж байна, шүүхийн үйлчилгээ өмнөхөөсөө мэдэгдэхүйц сайжирч байна, эвлэрүүлэн зуучлал үр дүнтэй хэрэгжиж байгаа гэдэгтэй хамгийн их санал нийлжээ. Түүнчлэн шүүхийн үйлчилгээнд цахим инновац нэвтэрсэн, шүүхийн шийдвэр нээлттэй, үйл ажиллагаа нь ил тод болсон гэдэгтэй иргэдийн олонх санал нийлжээ.

Харин шүүх бие даасан захиргаатай болсон, шүүхийн хараат бус байдал дээшилсэн, шүүхийн хүний нөөц шинэчлэгдэж байгаа, шүүх дагнаж, шүүгч мэргэшсэн зэрэг шинэтгэлийн өөрчлөлтүүд иргэдэд харьцангуй бага мэдрэгдсэн байна. Иймд эдгээр чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг илтгэнэ.

Энэ удаад шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэхийн тулд цаашид юунд анхаарах талаар иргэд Шүүгчид сайн хүнийг томилох, Шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, Мэдээллийн ил тод байдлыг хангах, Шүүгчийн нөлөөлдөг танил талын нөлөөг хаах гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчдын 35.8 хувь нь шүүгчийн мэдлэг, чадварт эргэлздэг гээд цаашид Шүүгчид сайн хүнийг томилох (40.6%), 33 хувь нь шүүгчид нөлөөлдөг танил талын нөлөөг хаах гээд Мэдээллийн ил тод байдлыг хангах (36.3%), зэрэг шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлагатайг тус судалгаа өгүүлж байна.

Судалгааны үр дүнд тулгуурлаж дараах товч зөвлөмжийг гаргаж байна.

- Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог сайжруулах, шүүхийн ажилтнуудыг урьдчилж бэлтгэдэг институттэй болох, шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх;
- Шүүгчийн хараат бус ажиллах баталгааг бий болгох, энэ талын үйл ажиллагааг идэвхжүүлж иргэд олон нийтэд сурталчлах
- Шүүгчийн тоог нэмэгдүүлэх, шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх;
- Шүүхийн үйлчилгээг орчин үежүүлэх чиглэлээр төсөв хөрөнгийг шийдвэрлэх, шүүхийн мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг сайжруулах;
- Шүүхийн дэд бүтэц, нэн ялангуяа нийслэл дэх шүүхүүдийн дэд бүтцийг оновчтой бүрдүүлж, шүүхээр үйлчлүүлэгч иргэд шүүхийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлэх;
- Шүүхийн нэр хүнд, шүүгчид итгэх олон нийтийн итгэл буурах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг тогтмол өсгөх чиглэлд төлөвлөгөөт арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх;
- Шинэтгэлийн чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх.

Боловсруулсан:

Д.Аюуш /ШСМСХ-ийн Социологич-судлаач/

ХАВСРАЛТ

Хүснэгт №1. Судалгаанд хамрагдсан хүний тоо

№	Шүүх	Үйлчлүүлсэн	Үйлчлүүлээгүй
1	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар	40	40
2	Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар	40	40
3	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар	40	40
4	Завхан аймаг дахь шүүхийн тамгын газар	39	41
5	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	40	40
6	Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар	40	49
